

МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

2022 оны .... сар.....өдөр

Дугаар\_\_\_\_\_

Улаанбаатар хот

13 нас хүрсэн хүний эрхэлж болох хөнгөн ажлын төрөл, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 142 дугаар зүйлийн 142.4 дэх хэсгийн үндэслэн ТУШААХ нь:

1. 13 нас хүрсэн хүний эрхэлж болох хөнгөн ажлын төрөл, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг хавсралтаар баталсугай.

2. Уг тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Өнөрбаяр/-д даалгасугай.

САЙД

А.АРИУНЗАЯА

### **13 нас хүрсэн хүний эрхэлж болох хөнгөн ажлын төрөл, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл**

#### Ажлын цаг, хугацаа:

Хичээлийн үед долоо хоногт 15 цагаас илүүгүй хугацаагаар ажиллуулж болно.

- 1.Хичээлийн үед өдөрт ажиллах цаг: 2 (долоо хоногт нийтдээ 10 цаг)
- 2.Гэр ахуйн ажил хийх нийт цаг: 1 (долоо хоногт нийт 5 цаг)

Хичээлийн улирлын амралын үед 20 цагаас илүүгүй хугацаагаар ажиллуулж болно.

- 1.Даваагаас Баасан гарагт нийт ажиллах цаг: өдөрт 2 цаг
- 2.Долоо хоногийн амралтын өдрүүдэд нийт ажиллах цаг: 2 цаг
- 3.Улирлын амралтын үед гэр ахуйн ажил хийхэд: 8 цаг

Хөнгөн ажил хийх тасралтгүй ажлын цагийн үргэлжлэлийн явцад тогтмол хугацаанд завсарлах шаардлагатай. Завсарлагын хугацаанд ус уух зэрэг боломжоор хангана.

Хүүхэд долоо хоногт хамгийн багадаа нэг өдөр ажил хийхгүйгээр амрах ёстой.

13-15 настай хүүхэд долоо хоногийн 5 өдрөөс илүү өдөр ажиллахыг зөвшөөрөхгүй.

Хүүхэд хичээлийн болон хичээлийн бус улирлын амралтын өдөр байснаас үл хамааран оройн 6 цагаас өглөөний 6 цагийн хооронд ажиллахыг зөвшөөрөхгүй. Хүүхэд амрах, тоглох хангалттай цагтай байх, түүнчлэн хүүхэд шөнийн цагаар ажиллахтай холбоотой унах, хальтрах эрсдлээс хамгаалагдсан байх шаардлагатай.

#### А. Хөдөлмөрийн нөхцөл

13-15 настай хүүхдийг дараах нөхцөлд ажиллуулахгүй:

- Байнгын, шууд хяналтгүйгээр ажиллах
- Тухай ажил үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай зохих сургалтад хамрагдаагүй
- Гэр бүлээсээ гадуур, хол байх
- Ганцаараа эсвэл олон цагаар тусгаарлагдан ажиллах

Эдгээр бүх нөхцөл 15-17 настай хүүхдүүдэд нэгэн адил хамаарна.